

## Монголын эдийн засгийн хөгжил ба ядуурал

*Б. Энхцэцэг*

*МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт*

*Судалгааны Төвийн магистрант*

### Агуулга

1990 оноос эхлэн Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт эрс өөрчлөлт явагдаж байна. Энэхүү шилжилтийн үе өөрийн гэсэн сөрөг үр дагавруудыг авчирсан бөгөөд ард түмний амьжиргааны түвшинг буурч, ядуурал нэмэгдэх болсон. Үүнд:

Монгол улсын зах зээлийн харилцаанд шилжих үйл явц эдийн засгийн гадаад,дотоод нөхцөл байдалд үүссэн тааламжгүй өөрчлөлтийн үед явагдаж байгаагаас үүдэн хямрал ,бэрхшээл тулгарч байна.1990 оныг хүртэл Монгол улс сонгодог төлөвлөлтийн эдийн засагтай орон байв. Монгол улс төвлөрсөн төлөвлөлтийн дор харьцангуй сайн хөгжиж ирсэн бөгөөд дан мал аж ахуйн орноос нийгмийн өндөр үзүүлэлттэй харьцангуй аж үйлдвэржсэн орон болж хөгжсөн. Гэхдээ, төвлөрсөн төлөвлөлтийн орнуудын адил үйлдвэрийн суурь нь өрсөлдөөнт зах зээлийн хэвийн нөхцөлд амьдрах чадваргүй, эдийн засгийн гажуудалд нэрвэгдсэн үр ашгийн үзүүлэлт султай, ЭЗХТЗ-ийн хүрээнд хоршиход чиглэгдсэн бүтэцтэй болж хувирсан. Монголын тухайд хуучин ЗХУ-с авах импорт, санхүүгийн тусламжаас эдийн засаг хэтэрхий хараат болсон байв. ЭЗХТЗ-ийн систем задран унаж Зөвлөлтөөс орж ирж байсан хөрөнгө зогссон нь Монголын эдийн засгийг нэн хүнд байдалд оруулсан юм.

Монгол улс ТТЭЗ-С ЗЗЭЗ-г шилжих болсон нь өмнөх тогтолцооны үед олон жилээр хэвшил болж тогтсон нийгмийн хамгаалалтын систем задарч ,айл өрх хувь хүмүүсийг нийгмээс дэмжин тусламж үзүүлэх замаар амьдралын түвшинг жигд байлгаж,амьдрах тааламжтай нөхцлийг бүрдүүлж байсныг өөрчлөхөд хүргэсэн.

ТТЭЗ-ийн үед улсаас олон хүүхэдтэй айлд хүүхдийн тэтгэмж олгох ,нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх,хөнгөлттэй үнээр хүүхдээ цэцэрлэг,яслид

хүмүүжүүлэх ,хүн бүр бүх шатны сургуульд үнэ төлбөргүй суралцаж боловсрол эзэмшиж,эмнэлгийн бүх үйлчилгээг үнэ төлбөргүй авах гэх мэт хэрэглээний хүрээнд хүн бүрт ижил нөхцлийг бий болгоход анхаарч байсан нь бэлэнчлэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд нөлөөлжээ.Ялангуяа олон хүүхдийг төрүүлж өсгөх бодлогыг төрөөс дэмжиж урамшуулж ирсэн нь өнөөдөр олон хүүхэдтэй айл өрх ,хөдөлмөрлөх чадваргүй хүн амд шинэ нөхцөлд өөрөөр хэлбэл хуучин тогтолцоо үеэ өнгөрөөж зах зээлийн нөхцөлд бусдын гарыг харалгүй бие дааж ажиллаж,амьдрахад ихээхэн хүнд байдлыг бий болгож, ядууралд хүргэх нэг шалтгаан болж байна.

33ЭЗ-ийн механизм ажиллах нэг гол нөхцөл бол үнэ чөлөөтэй байх явдал юм.Ийм ч учраас манайд бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг дэс дараалалтайгаар чөлөөлсөн.Үнэ чөлөөтэй тогтоодог болсон үед ховор барааны эрэлт нэмэгдэж ,үнэ өсдөг зүй тогтлын дагуу хэрэглээний барааны үнийн түвшин өсч , төгрөгийн худалдан авах чадвар унав.Үүнийг өрх гэрүүдийн орлогын өсөлттэй харьцуулж судлахад орлогын өсөлт нь үнийн өсөлтөөс хоцорч байдаг утгаараа айл өрхүүдэд харилцан адилгүй буюу бага болон тогтмол орлоготой өрхийн хувьд орлогын өсөлтийн хувь нь ижил байгаа ч үнийн өсөлтийн ижил түвшинд худалдан авах чадвар ихээр буурч байна.Ялангуяа ядуу хүний хэрэглэдэг барааны үнэ тэдний орлогын өсөлттэй харьцуулбал илүү түргэн өссөн байдаг нь орлого багатай айл өрхүүдийн ядуурах нэг гол шалтгаан болж байна.

Хуучин тогтолцооноос 33ЭЗ-ийн тогтолцоонд шилжих шилжилтийн үед монголын эдийн засаг уналтанд орлоо.Энэ уналт нь 2 гол хүчин зүйлээс шалтгаалж байна.Нэгд,хуучин тогтолцоог халж, эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байсан хуучин аргуудыг хэрэглэхээ больсон ,зах зээлийн тогтолцооны шинэ арга хэрэгсэл бүрэн дүүрэн цэгцэрч хараахан чадаагүй байгаа нь завсарын /шилжилтийн/ энэ үед эдийн засаг уналтанд орох нэг шалтгаан болж байна. Хоёрт,эдийн засаг мөчлөг шинж чанартай бөгөөд энэ үүднээс авч үзвэл эдийн засгийн мөчлөгийн уналтын үе манай орны эдийн засгийн шилжилтийн үетэй давхцаж байна. Эдийн засгийн бууралтаас ажил эрхлэлтэд тусах нөлөө 1993 оноос илэрч, ажилгүйдэл мөн онд 54-өөс 72 мянга болон өсч, ажил эрхлэлт 13 орчим хувиар буурсан байна. Эдийн засгийн уналтын үед ажилгүйдэл нэмэгдэж байна.Мөчлөгийн ажилгүйдэл нь шилжилтийн ба бүтцийн ажилгүйдлээс зарчмын ялгаатай бөгөөд эдийн засагт

ажилгүйдлийг авч үзэхдээ зөвхөн мөчлөгийн ажилгүйдлийг гол болгодог. Дээрх шалтгаанаас үндэслэн манайд ажилгүйдэл өссөн нь ядуурлыг нэмэгдүүлэх бас нэг хүчин зүйл боллоо.

Орлого багатай ядуу айл өрхүүд нь мэдлэг чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох, эзэмшсэн мэргэжлээ өөрчлөх, шинэ мэргэжил эзэмшихэд төлбөрийн чадвар дутагдалтай учраас чадварын ядууралд орох явдал нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн үед ерөнхий боловсролын сургууль завсардах, сургуулиас гарах, сургуулийн насны хүүхэд сургуульд хамрагдахгүй байх зэргээр бидний нүдэнд ажиглагдаж байгаа хэлбэрээр ядууралд орогсдын тоо өссөөр байна. Бүрэн бус мэдээгээр 1990 оноос хойш 146 мянган хүүхэд сургуулиас завсардсан нь дараагийн шатны сургуульд суралцах боломж үгүйсч байгаа төдийгүй энэ хүүхдүүд хөдөлмөрийн насанд хүрсэн үедээ зөвхөн биеийн хүчин шаардах энгийн ажлыг гүйцэтгэхээс хэтрэхгүй байдалд хүрнэ. Энэ нь нарийн мэргэжлийн хөдөлмөрийг бодвол бүтээмж доогуур орлого багатай байдаг болохоор тодорхой хэмжээгээр орлогын болон чадварын ядууралд зэрэг ороход хүргэх юм.


Өнөөдөр орон гэргүй тэнэмэл хүүхдийн тоо өслөө. Тэнэмэл хүүхдийн хүмүүжил доголдож, хулгай дээрэмд өртөх, эрүүл ахуй, хоол тэжээлийн наад захын хэм хэмжээ мөрдөгдөж чадахгүйд хүрч эмгэг өвчтэй, согогтой болж өсдөг нь бас л чадварын доройтолд орох үндэс суурь болж байна. Янз бүрийн халдварт өвчнөөр өвдсөний үр дагавар болж зарим тохиолдолд оюуны хомсдолтой нийгэмд хөдөлмөр эрхлэх чадваргүй болдог нь мөн л чадварын ядууралд хүргэнэ.

Ядуурлын шалтгаан, шинж байдал хот, хөдөөд ялгаатай байна. Хотод үйлдвэрлэлийн уналт, ажилгүйдэл өссөнөөс ажлын хөлснөөс өөр амьдралын эх сурвалжгүй хүмүүс орлогын ядууралд орж байна. Мөн эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд байгаль цаг уурын гэнэтийн бэрхшээлээс малчид амьжиргааны гол эх үүсвэр болох малаасаа салж ядуурах нэг нөхцөл болж байна. Хөдөөгийн ядууралд нийгмийн үйлчилгээний хомсдол илүү нөлөөлж байна. Малчид хувийн өмчтэй болсноор ажиллах хүч дутагдаж, хүүхдээ сургуулиас завсардуулан МАА дээр ажиллуулах үзэгдэл гарах болов. Ядуучууд хүүхдийн хувцас, ном дэвтэр авах бэл бэнчингүйдэн хүүхдээ сургуулиас гаргаж байна.

### 1000 Монгол дахь ядуурлын төлөв байдал

Зах зээлийн өргөтгөсөн харилцаанд шилжих үед монголын нийгэмд байгаа нэг хурц асуудал бол амьжиргааны түвшин буурч ядуурал нэмэгдэх болсон явдал билээ. Засгийн газраас макро түвшний бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа нарга хэмжээнүүдийн дунд улс орны эдийн засагт зарим нааштай өөрчлөлт гарч буй боловч энэ нь ард түмний амьдралын түвшнийг тодорхойлогч хүчин зүйл болж чадахгүй байна. Шилжилтйн үед эдийн засгийг удирдахад учирч байгаа бэрхшээл гадны цохилтын нөлөөллийн улмаас 1990-1993 оны хооронд бодит ДНБ нийтдээ 20 хувиар буурсан. Хуучин ЗХУ-ын үзүүлж байсан тусламж зогссон, ЭЗХТЗ задарсан зэрэг нь гадаад худалдаа бараг зогсоход хүргэсэн. Зөвлөлтийн санхүүжүүлж байсан төслүүд зогссоноор түлш шатахуун, цемент зэрэг чухал барааны хангамж тасарч энэ нь аж үйлдвэр, барилга байгууламжид ноцтой нөлөөлсөн бөгөөд эдгээр салбарын үйлдвэрлэл 25%, 70%-р хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэл 18%-р тус тус буурчээ. (Дэлхийн Банкны Баримт бичиг)

Улс орны эдийн засаг 1990-1993 он дуустал унаж, 1994 оноос ҮНБ-ний үйлдвэрлэл ялимгүй өсч эхэлсэн байна. Энэ өчүүхэн өсөлт хүн амд нэлээд нитгэл төрүүлж байгаа боловч амьжиргааны түвшинг дээшлүүлэх, улам бүр газар авч буй ядуурлыг багасгахад нөлөө үзүүлж чадахгүй юм.



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1996 он

Чөлөөт үнийн тогтолцоонд шилжсэн ,валютын ханш өөрчлөгдсөн зэргийг дагалдан,бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөөгүй,хөдөлмөрийн бүтээмж нэмэгдээгүй байтал бараа үйлчилгээний үнэ тариф өссөөр байна. 1992 он гэхэд л үнэ тариф 325 хувь буюу бараг 4 дахин өсч ,мөнгөний ханш уналтын хурдцаар дэлхийд эхний 10 –т орох болсон юм.1991 оны Iсарын 16–наас эхлэн тооцвол 1995 оны 1.1 гэхэд үнэ тариф 35 дахин өссөн ба харин 1996 онд имфляци 53 хувь болж буурсан байна.

Нийт хүн амын амьжиргааны түвшин буурч байгаа нь эдийн засгийн төдийгүй ,соёл боловсрол,эрүүлийг хамгаалах,дэд бүтцийн хөгжлийг хойш татах нэг хүчин зүйл болон хувирч байна. Өрхийн аж ахуйн судалгаагаар шилжилтийн үе эхэлснээр амьжиргааны баталгаажих доод түвшнээс доош орлоготой ядуу өрх 1994 онд 99.8 мян,1995 онд 80.4 мян, 1996 онд 103.5мян, 1997 оны 07.01–ны байдлаар 118.5 мянга буюу 5 өрх тутмын нэг нь ядуу өрх байгаа нь манай улсын хувьд өндөр үзүүлэлт юм.

1991 онд нийт хүн амын 14,5 нь ядуу байсан бол 1992 онд 17 хувь, 1996 онд 19,2 хувь болж өссөн байна. Харин Дэлхийн Банкнаас явуулсан Амьжиргааны түвшинг хэмжих судалгаагаар 1995 онд ядуурлын түвшин 36 хувь байсан байна.


**Хүснэгт: Ядуурлын түвшин (хувиар), ядуучуудын тоо**

Он	Ядуурлын түвшин ( нийт хүн амд эзлэх хувь)			Ядуучуудын тоо		
	Хөдөө	Хот	Улсын хэмжээнд	Хөдөө	Хот	Улсын хэмжээнд
1991	-	-	14.5	-	-	320513
1992	-	-	17.7*	-	-	287676*
1993	19.5	16.5	17.8	198717	202990	401707
1994	26.1	15.1	20.2	276366	183982	460348
1995	16.6	14.7	15.6	184757	176939	361696
1996	19.8	18.7	19.2	222955	229450	452405

Мэдээллийн эх үүсвэр: УСГ, Өрхийн аж ахуйн судалгаа

Тайлбар: \* – Зарим аймгуудын мэдээлэл дутуу

1000 өрхөд ногдох ядуу өрхийн тоогоор Дорноговь, Орхон, Дундговь, Дархан-Уул аймгууд улсын дунджаас доогуур байхад Баян-Хонгор, Говь-Сүмбэр, Архангай, Хөвсгөл, Өвөр-Хангай, Өмнөговь, Баян-Өлгий аймгууд нэлээд их байна. Хот суурин газруудын дотор аймгуудын төвд ядуурлын түвшин өндөр байна.



Нийт ядуу өрхийн ам бүлийн тоо 1994 онд 460,3 мянга, 1995 онд 361,7 мянга, 1996 онд 452,4 мянга, 1997 оны 07.01-ны байдлаар 548,7 мянга байна.

Орлого багатай бусад улс оронд түүний дотор зах зээлийн харилцаанд шилжиж буй орнуудад хөдөө орон нутагт ядуурал их байдаг бол Монгол төв сууринд хүн амын 38 хувь ядуу харин хөдөө орон нутагт 33 хувь нь ядуу гэсэн судалгааг гаргажээ. (Дэлхийн Банкны Баримт Бичиг) Хот сууринд хөдөөтэй харьцуулахад ядуурал илүү, ноцтой байдалтай байгаа нь ядуус гол төлөв төв сууринд амьдарч байгаатай холбоотой бөгөөд төв сууринд улсын үйлдвэрүүд олноороо хаагдсан, үйлдвэрлэл буурсан болон хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн их байгаа явдал эн байдлыг улам лавшруулж байна. Улсын үйлдвэрүүд хаагдсаны улмаас ажилгүйдэл их болон мөн хөдөө орон нутгаас олон тооны хүмүүс шилжин суурьшсан зэргээс аймгийн төвд ядуурлын түвшин хамгийн өндөр байна. Өрхийн аж ахуйн судалгаанаас үзэхэд

ядуучуудын 41 хувь нь аймгийн төвд, 23 хувь нь сумын төвд, 12 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Ийнхүү ядуу амьдралтай хүмүүсийн ерөнхий байдлыг авч үзвэл ам бүл олонтой, аминдаа малгүй буюу цөөн малтай, ажиллах чадваргүй юм уу ажиллах чадвартай боловч ажилгүйгээс хүнс тэжээл бусад хэрэгцээт зүйлээ худалдаж авах чадваргүй хүмүүс юм. Гэтэл нэн ядуу амьдралтай хүмүүс гэдэгт өмсөх хувцасгүй, аминдаа малгүй, цалин хөлс, тэтгэмж, тэтгэвэр авдаггүй, ямар нэг орлогогүй, орон гэргүй, насан өндөр юм уу эрүүл мэндээс шалтгаалах ажил эрхлэх чадваргүй, тахир дутуу, ой ухааны хомсдолтой, харж хандах хүнгүй, өнчин өрөөсөн хүүхдүүд хамаарагддаг. Ядуу хүмүүст дээр дурдсан шинж чанар бүхий амьдралтай хүмүүс голчлон хамаарагдаж байгаагаас гадна тахир дутуу, өвчний улмаас харах, сонсох боломжгүй иргэд, хэвтрийн өвчтэй иргэд хамаарагдаж байна.

Ядуу хүмүүсийн дотор зонхилох хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь хотод ч, хөдөөд ч адилхан бөгөөд эмэгтэй хүн нийгэм, гэр бүлийнхээ өмнө давхар үүрэг хүлээж байдагтай нэлээд хэмжээгээр холбоотой. Эмэгтэйчүүд үр хүүхдээ төрүүлж өсгөхийн зэрэгцээ эрэгтэйчүүдийн нэгэн адил нийгмийн өмнө хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэж давхар ачаалал үүрч байдаг нь шилжилтийн эдийн засгийн үед улам хүндэрч байна. Амьдрахын эрхээр бодит орлого улам бүр буурч байгаа өнөө үед эмэгтэйчүүд өөрийн хүч чадлыг дайчлан хөдөлмөрлөж байгаа ч мэдлэг, мэргэжил, авьяас чадвараа дээшлүүлэх өөрийгөө хөгжүүлэх цаг хугацаа, мөнгө хөрөнгө, дэмжлэг дутагдалтай гаас ядууралд илүүтэй өртөж байна.

Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурснаар илэрч байгаа төдийгүй, хоол тэжээлийн илчлэг дутагдсанаас ядуу хүмүүсийн эрүүл мэнд муудах, боловсрол, соёлын хэвийн үйл ажиллагаа алдагдаж хүүхэд сургууль завсардах, тэнүүчлэх, гэмт хэрэг зөрчилд өртөх, нийгэм ёс суртахууны доройтолд орох зэрэг сөрөг үр дагавартай байна. Хэрэв ядуурлын одоогийн түвшин хэвээр байх буюу цаашид нэмэгдвэл зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц удааширч, өөрчлөлт шинэчлэлтийн бодлого, үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

## Монголын эдийн засгийн өнөөгийн байдал

Гадаад өөрчлөлтийн улмаас бий болсон эдийн засаг нийгмийн хямрал нь тогтворжуулалтын хатуу бодлого явуулж, бүтцийн гүнзгий өөрчлөлт хийхийг шаардсан. Монголд ядуурлын түвшин өндөр, орлого бага байгаад нөлөөлж байгаа эдийн засаг нийгмийн хүчин зүйлийн үйлчилгээг ойлгох явдал нэн чухал байна. 1990-ээд оны эхэн үед Монголын эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд эрс буурч ирсэн ба зөвхөн сүүлийн 3 жилд тогтворжиж эхлэж байна.

1994 оноос хойш нэг хүнд ногдох ДНБ жилд дунджаар 2.8 хувиар өсөж байхад инфляци буурсан байна. Хэдийгээр нэг хүнд ногдох ДНБ-д өсөлт гарч байгаа ч сүүлийн үед ядуурал нэмэгдсээр байгаа бөгөөд 1991 оноос хойш бусад жилүүдтэй харьцуулбал 1995 онд хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. 1995 онд ДНБ 6.3 хувиар өссөн бол харин 1996 онд 2.6 хувь болж буурчээ. Нэг хүнд ногдох ДНБ 1993 онд 188 ам.доллар, 1995 онд 195.1 ам. доллар болон өссөн байна.

Орлогын хувиарлалтыг зохицуулах арга замуудын нэг болох ажил эрхлэлтэд өрчлөлт гарч байна. Манай улсын хүн ам 1996 оны эцсийн байдлаар 2353 мянгад хүрч 1086.7 мянган хүн буюу нийт хүн амын 46.2 хувь нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн ам эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хүн ам дунджаар 1,5 орчим хувиар өсч, нийт ажиллах хүч 3.0 орчим хувиар өсч байна. Ийнхүү манай оронд хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын өсөлтөөс илүү хурдацтай өсөж байгаад төрөлтийн бууралт, манай орны хүн амын насны залуу бүтэцтэй холбоотой. Хөдөлмөрийн нөөц өсөөд байхад ажлын байрны тоо төдийлөн нэмэгдэхгүй зарим салбарт тухайлбал, төсвийн байгууллага, улсын үйлдвэрийн байгууллагад ажиллагсдын тоо буурч байгаа нь зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн тоо өсөхөд нөлөөлж байна.

1990 оноос өмнө Монгол оронд ажилгүйдэл тун бага, тогтвортой байсан. 1989 оны байдлаар улсын хэмжээнд 36 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй байсан бол



Монголын хүн ам тэдний сэтгүүл, эмхтгэл 3, дугаар 1 арваннэгдүгээр сар, 1997

шилжилтийн үед ажил эрхлэлт ба ажилгүйдлийн хэмжээнд өөрчлөлт гарч 1991 онд 6.5 хувь, 1992 онд 6.3 хувь, 1993 онд 8.5 хувь, 1994 онд 8.7 хувь, 1996 онд 6.5 хувь болсон байна. Ийнхүү 1993, 1994 онуудад ажилгүйдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн нь эдийн засгийн шинэ тогтолцоог бий болгохын тулд Засгийн газраас авч явуулсан бүтцийн өөрчлөлт, өмч хувьчлал, үнийн чөлөөлөлт зэрэгтэй холбоотой. Харин 1995 оноос ажилгүйдлийн түвшин буурсан нь үйлдвэр, үйлчилгээ сэргэж эхэлсэнтэй холбоотой.

Эдийн засгийн үүднээс ажилгүйдлийн бараг 60 хувь нь ядуурлын түвшинд амьдарч байна. Өөрөөр хэлбэл ажилгүйдэл ядууралд хүргэдэг. Дээрх ажилгүй хүмүүс дээр нэмээд жил бүр хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж байгаа 25 000 орчим хүмүүсийг ажлын байраар хангах эдийн засгийн тогтвортой өсөлт хэрэгтэй. Монгол орны хувьд ажил эрхлэлтийг сайжруулж, хүмүүний баялагаа үр ашигтай ашиглах нь амьжиргаагаа дээшлүүлэх нэг гол нөхцөл болж бана. Эдийн засаг сэргэхийн дагуу гол төлөв мал аж ахуй, үйлчилгээний салбарт ажил эрхлэлт 1994 онд 1.7 хувь, 1995 онд 2 хувиар тус тус нэмэгджээ. Гэхдээ энэ хандлага бэхжиж чадахгүй байна. Ийм учраас эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, ялангуяа хүний хөдөлмөрийн эрэлтийг нэмэгдүүлж, ядуу дорой хэсгийг эдийн засгийн амьдралд хамран оролцуулахад чиглэсэн идэвхтэй бодлого явуулах нь ажилгүйдэл, ядууралтай тэмцэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх юм.

### **Ядуурлыг бууруулах шаардлага**

Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурснаар илэрч байгаа төдийгүй, хоол тэжээлийн илчлэг дутагдсанаас эрүүл мэнд муудах, боловсрол, соёлын үйл ажиллагаа хямарч, оюуны хоосролд орох, хүүхэд сургууль завсардах, тэнүүчлэх, нийгэм ёс суртахууны доройтолд орж, гэр бүл салах, хүүхэд өнчрөх, гэмт хэрэг өсөх зэрэг ноцтой сөрөг үр дагавартай байна. Тэрчлэн ажилгүйдэл хагас ажилгүйдэл нэмэгдэж буй нь хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглаж үйлдвэрлэл үйлчилгээ явуулах ихээхэн боломжийг алдаж байна. Хэрэв ядуурлын одоогийн түвшин хэвээр байх буюу цаашид нэмэгдвэл

зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц удааширч, өөрчлөлт шинэчлэлийн өргөн цар хүрээтэй бодлого, үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Ийнхүү ядуурал бий болох үндсийг арилгах, ядуурлыг бууруулах, ядуурлаас гарах оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна.

**Дүгнэлт**

Ийнхүү эдийн засгийн байдал хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд Монгол улс хөгжлийнхөө стратегийг ядуурлыг бууруулах бодлоготой уялдуулан зохицуулах шаардлагатай байна. Ядуурлыг туштай бууруулж, нийгмийн бусад асуудлыг туйлбартай шийдвэрлэхэд өндөр үр ашигтай микро эдийн засаг, хариуцлагатай макро бодлого, тэдгээрт түшиглэсэн эдийн засгийн тогтвортой өсөлт зайлшгүй шаардлагатай. Үйл ажиллагаа нь зохих ёсоор явагдаж, ялангуяа эдийн засаг дахь өсөлт нь хурдан хэрэгжиж үр ашигтай ажиллаж байгаа зах зээл хүний хөгжлийг хангаж чадна. Монголд ядуурал их байгаа учир зөвхөн эдийн засгийн өсөлтийг хангаж байж ядуурлыг бууруулах бололцоо бүрдэнэ гэж үзэж байна.

**Ашигласан материал:**

1. Монголын хүний хөгжлийн илтгэл 1997 он
2. Дэд. док, Дэд проф Б. Сувд " Монгол дахь ажил эрхлэлтийн байдал" 1996 он
3. Шилжилтийн эдийн засаг дахь ядуурлын үнэлгээ

Дэлхийн Банкны баримт бичиг					
4. "Ядуурал ба нийгмийн хамгаалал" сэдэвт семинарын материал					
Ц. Батболд "Тогтворжуулалт ба бүтцийн өөрчлөлт нийгмийн салбарт нөлөөлөх нь "	1996 оны 12-р сар				
Б. Бямбаа " Ажилгүйчүүд ба ядуурал"	1996 оны 12-р сар				